

**ЗАРИМ ГАЗАР НУТГИЙГ УЛСЫН ТУСГАЙ ХАМГААЛАЛТАД АВАХ ТУХАЙ
УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙГ АНХНЫ ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ
БЭЛТГЭСЭН ТАЛААРХ БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУИН
БАЙНГЫН ХОРООНООС ГАРГАСАН САНАЛ, ДҮГНЭЛТ**

2016 оны 1 дүгээр
сарын 20-ны өдөр

Улаанбаатар
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын
гишүүн Л.Эрдэнэчимэг**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2015 оны 10 дугаар сарын 23-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдуулсэн Зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх асуудлыг 2015 оны 10 дугаар сарын 30, 12 дугаар сарын 24-ний өдрийн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Байнгын хороо 2016 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн хуралдаанаар тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг хийхэд Улсын Их Хурлын гишүүн Ж.Энхбаяр зарим газар нутгийг байгалийн нөөц газар болон дурсгалт газрын ангиллаар улсын тусгай хамгаалалтад авах шийдвэрийг Улсын Их Хурал гаргасны дараа хилийн цэсийг тогтоох нь Засгийн газрын бүрэн эрхийн асуудал мөн эсэх талаар асуулт асууж, ажлын хэсгээс тодруулга авав.

Тогтоолын төслийг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх үед Улсын Их Хурлын гишүүн С.Оюун, Ц.Оюунгэрэл, Л.Эрдэнэчимэг нар тогтоолын төслийн 1 дүгээр заалтад “Борнуур” гэсний дараа “, Батсүмбэр” гэж нэмэх гэсэн санал гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын гишүүн Х.Болорчулуун “Байгалийн унаган төрхөө харьцангуй хадгалсан, түүх соёл, шинжлэх ухааны болон танин мэдэхүйн, экологийн хүмүүжилд ач холбогдол бүхий газар нутаг болох Сэлэнгэ аймгийн Мандал сумын нутагт орших Ноён уулын орчмын газар нутаг болон Төв аймгийн Борнуур сумын нутагт орших Ноён уул орчмын газар нутгийг байгалийн цогцолборт газрын ангиллаар улсын тусгай хамгаалалтад авч, газар нутгийн хилийн заагийг хавсралтаар баталсугай” гэсэн саналыг бичгээр томьёолж ирүүлсэн нь өргөн мэдуулсэн тогтоолын төслийн үзэл баримтлалтай зөрчилдөх тул уг саналын томьёоллоор санал хураалгаагүй болно.

Улсын Их Хурлын гишүүн О.Баасанхүү “Нөөц газрын ангиллаар тогтоохдоо Засгийн газраас хилийн цэсийг байгалийн тогтооцоор нь бүхэлд нь авахыг үүрэг болгох” гэсэн санал гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй тул тэрээр цөөнх болов.

Зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг зарчмын зөрүүтэй саналын томьёоллын хамт Та бүхэнд тараасан болно.


Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа:

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС
ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Л.ЭРДЭНЭЧИМЭГ



Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлэгт

2016.01.20

**ЗАРИМ ГАЗАР НУТГИЙГ УЛСЫН ТУСГАЙ ХАМГААЛАЛТАД АВАХ ТУХАЙ
УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ТАЛААРХ БАЙГАЛЬ ОРЧИН,
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНООС ГАРГАСАН ЗАРЧМЫН
ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ**

**Нэг.Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн
байнгын хорооны дэмжсэн санал:**

- 1.Тогтоолын төслийн 1 дүгээр заалтын "Борнуур" гэсний дараа ",Батсүмбэр" гэж нэмэх.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн С.Оюун, Ц.Оюунгэрэл,
Л.Эрдэнэчимэг**

**Хоёр.Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн
байнгын хорооны дэмжээгүй санал:**

- 1."Нөөц газрын ангиллаар тогтоохдоо Засгийн газраас хилийн цэсийг байгалийн тогтооцоор нь бүхэлд нь авахыг үүрэг болгох"

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн О.Баасанхүү